

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
..... дугаар сарын өдрийн
.....захирамжийн нэгдүгээр хавсралт

НИИСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ТӨРӨЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улаанбаатар хотын хөгжил цэцэглэлт, иргэдийн сайн сайхны төлөөх үйлсэд эрхэлсэн ажил, эрдэм мэдлэг, авьяас чадвараараа үнэтэй хувь нэмэр оруулсан нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажилтнууд, дотоод, гадаадын иргэд, оюутан, сурагчдыг урамшуулахад энэ журмын зорилго оршино.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Нийслэлийн Засаг даргын шагнал нь дараах төрөлтэй байна.

а/ Улаанбаатар хотын “Хүндэт тэмдэг”;

б/ "Нийслэлийн тэргүүний ажилтан" цол, тэмдэг;

в/ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн “Жуух бичиг”;

г/ Шилдэг оюутанд олгох Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг;

д /Шилдэг сурагчид олгох Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит шагнал.

Гурав. Шагналд нэр дэвшигчдэд тавигдах болзол, шаардлага

3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад 12-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан албан хаагчдыг “Хүндэт тэмдэг”-ээр, 8-аас доошгүй жил ажиллаж салбарын хамт олноо ажлын үзүүлэлтээр манлайлагчдыг “Нийслэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 5-аас доошгүй жил ажиллаж хөдөлмөрийн амжилт үзүүлсэн албан хаагчдыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн “Жуух бичиг”-ээр тус тус шагнана.

3.2. Улаанбаатар хотыг хөгжүүлэх үйлсэд эрхэлж буй ажил хөдөлмөрийнхөө амжилтаар онцгой хувь нэмэр оруулсан нийслэлийн болон гадаадын иргэдийг “Хүндэт тэмдэг”, “Жуух бичиг”-ээр шагнаж болно.

3.3 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит нэг жилийн сургалтын тэтгэлгийг доорх болзол хангасан 10 хүртэлх нийслэлийн уугуул шилдэг оюутанд олгоно.

а/ магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд 4 ба түүнээс дээш улирал дараалан 3,5-аас дээш голч дүнтэй суралцсан байх,

б/ оюутны эрдэм шинжилгээ, судалгаа, техник технологийн уралдаан тэмцээн, урлаг, спортын зэрэг олон нийтийн үйл ажиллагаанд бусдыгаа манлайлан оролцдог, хамт олныхоо дунд нэр хүндтэй байх,

в/ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг нэг оюутанд хоёр дахь удаагаа, Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг хүртэгсдэд давхардуулан олгохгүй.

3.4. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит шилдэг сурагчийн шагналыг тухайн хичээлийн жилд зохиогдсон улсын болон олон улсын хэмжээний олимпиад, урлаг, спортын олон улсын уралдаан тэмцээнд тэргүүлсэн нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 30 хүртэлх сурагчид жилд нэг удаа олгоно.

3.5. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит шилдэг оюутны тэтгэлгийг батламж, шилдэг сурагчийн шагналыг гэрчилгээ дагалдана.

3.6. Энэ журмын 2-ын а, б, в-д заагдсан төрлийн шагналыг шат дараалах зарчмаар олгох ба өмнөх шагналаас хойш 3-аас доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээлийн түвшин нь ахисан нөхцөлд дараагийн шагналд нэр дэвшүүлнэ.

Дөрөв. Шагналыг дагалдах мөнгөн шагнал

4.1. Нийслэлийн Засаг даргаас олгох шагнал дараах мөнгөн шагналтай байна.

а/ Улаанбаатар хотын “Хүндэт тэмдэг” 50.000 төгрөг;

б/ Нийслэлийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг 40.000 төгрөг;

в/ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн “Жуух бичиг” 30.000 төгрөг;

г/ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит “Шилдэг сурагч” 30.000 төгрөг;

4.2 Шилдэг оюутанд олгох Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийн хэмжээг төрийн сургуулиудын тухайн үеийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн дундаж жишгээр тогтооно.

4.3. “Хүндэт тэмдэг”, “Нийслэлийн тэргүүний ажилтан”-ы үнэмлэх, “Жуух бичиг”, Шилдэг оюутны тэтгэлгийн батламж, шилдэг сурагчийн шагналын гэрчилгээн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч гарын үсэг зурж, тамга дарна.

4.4. Энэ журмын 4.1-ийн а, б, в-д заасан шагналын дагалдах мөнгөн шагналыг нэр дэвшүүлсэн байгууллага олгоно.

4.5. Энэ журмын 4.1-ийн а, б, в-д зааснаас бусад шагналын дагалдах мөнгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц санг төлөвлөх,

зарцуулах, гүйцэтгэлийг тооцох журам"-ын дагуу олгох бөгөөд хэмжээг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэл, дүүргийн удирдлагын шагналын төрөл, түүнийг олгох журам"-ын 3.3 дахь заалтыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Захирамжаар өөрчлөн тогтоож болно.

Тав. Шагналд нэр дэвшүүлэх

5.1. Нийслэлийн Засаг даргын шагналд нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж ажилтнаа нэр дэвшүүлж болох бөгөөд дараах бичиг баримт бүрдүүлсэн байна.

а/ нэр дэвшигчийн ажил байдал, амжилтын үзүүлэлтийн тухай тодорхойлолт;

б/ шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны албан бичиг;

в/ хамт олны хурлын тэмдэглэл;

г/ нэр дэвшигчийн анкет, мэдүүлэг /2,3 дугаар хавсралтаар/;

д/ нийслэлийн байгууллагад ажиллаж байгаа болон ажилласан жилийг тодорхойлох нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

е/ иргэний үнэмлэхний хуулбар;

ё/ өмнө нь нийслэлийн шагналаар шагнагдсан бол шагналын хуулбар;

ж/ нийслэлийн нутгийн захиргааны харъяалах дээд байгууллагын санал;

з/ аж ахуйн нэгж бйгууллагын татварын албаны тодорхойлолт, татвар төлөгч иргэний орлого татварын бүртгэлийн дэвтэр.

5.2. Дээрх материалуудыг шагнал гардуулахаас 15-аас доошгүй хоногийн өмнө Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.

5.3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба шагналд өөрийн санаачилгаар нэр дэвшүүлж болно.

Зургаа. Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх

6.1. Энэ журмын 4.1-ийн а, б, в-д заасан шагналаар шагнуулах хүсэлтийг дараах нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрийг тохиолдуулан хүлээн авна.

а/ Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр;

б/ Монгол Улсын нийслэлийн өдөр;

в/ Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр.

6.2 Шагнуулах хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч хүлээн авч, Нийслэлийн Засаг дарга, Тамгын газрын даргад танилцуулан, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн шагналын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

6.3.Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шагнуулах тухай тодорхойлолт, дагалдах материалыг нарийвчлан судалж шийдвэрийн төсөл,

боловсруулан холбогдох албан тушаалтнуудын саналыг авч, Засаг даргад танилцуулна.

6.4. Нийслэлийн Засаг дарга шагнах тухай асуудлыг захирамж гарган шийдвэрлэнэ.

6.5. Шагналыг түүхэн тэмдэглэлт ой, үйл явдлыг тохиолдуулан Нийслэлийн Төр Захиргааны байгууллагуудын төв ордон болон “Хангарди” ордны хүндэтгэлийн танхимд гардуулна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага өөрийн байранд гардуулж болно.

6.6. Шилдэг сурагчийн шагналыг жил бүрийн 6 дугаар сарын 1-нд буюу Хүүхдийн баяраар, шилдэг оюутны тэтгэлгийг жил бүрийн 10 дугаар сарын 29-нд буюу Монгол Улсын Нийслэлийн өдрөөр тус тус олгоно.

Долоо. Бусад

7.1. Улаанбаатар хотын “Хүндэт тэмдэг”, Нийслэлийн тэргүүний ажилтан” цол, тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн олгож болно. Нөхөн авахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

а/ Тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгохыг хүссэн өргөдөл;

б/ Иргэний үнэмлэхийн хуулбар;

в/ Зохих дансанд тэмдэг, үнэмлэхийн үнэ тушаасан баримт.

7.2. Шагнагдагсдын талаар дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

7.3. Шагналын материалыг архивын ажлын үндсэн зааврын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивлана.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
..... дугаар сарын өдрийн
.....захирамжийн хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛД
НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

- 1.Овог2. Нэр.....3. Төрсөн огноо.....
/он, сар, өдөр/
4. Хүйс:..... 5.Төрсөн аймаг, сум, хот.....
6.Одоогийн харьяалал:.....
/оршин суугаа аймаг, сум, хот/
7.Нийгмийн байдал:.....8. Регистр:.....
/эхний хоёр үсгийг заавал бичнэ/
9..Боловсрол:.....10.Ажилладаг салбар:.....
11.Мэргэжил:.....
12.Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№ Ажлын газрын нэр Хугацаа Эрхэлсэн ажил

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1			
2			
3			
4			
5			

13.Урьд нь шагнагдаж байсан нийслэлийн шагналууд:

№	Шагналын нэр	Хугацаа
1		
2		
3		
4		
5		

14. Шагнуулах ажлын үндэслэл, үзүүлэлт.....
.....

15. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

16. Хамт олны саналын хувь:

/Тодорхойлолт гаргасан байгууллагын тамга,
дарга /захирал/ -ын гарын үсэг
/он, сар, өдөр/

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
..... дугаар сарын өдрийн
.....захирамжийн гуравдугаар хавсралт

НИИСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН НЭРЭМЖИТ “ШИЛДЭГ ОЮУТАН”,
“ШИЛДЭГ СУРАГЧ”-Д НЭР ДЭВШИГЧИЙН МЭДҮҮЛЭГ

1.Овог:.....

2. Нэр.....

ЗУРАГ

3.Төрсөн он, сар, өдөр, газар:.....

4.Регистийн дугаар:.....

5.Оршин суугаа хаяг:.....

.....

6.Утас, и мэйл:.....

7. Суралцаж байгаа сургууль, анги, мэргэжил, голч дүн:

.....

.....

.....

8.Олон нийтийн сонгуульт ажил:

.....

.....

.....

9.Тэтгэлэгт нэр дэвшүүлэх үндэслэл, үзүүлэлт

.....

.....

.....

10. Нэр дэвшүүлж байгаа тэтгэлгийн нэр:

.....

...../Тодорхойлолт
гаргагч байгууллагын тамга, дарга /захирал/-ын
гарын үсэг/

/он, сар, өдөр/